



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/418

Хэрлэн сум

“Аян хур” ХХК-д тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын нутаг дэвсгэр дэх Үүц нэртэй 349,84 гектор талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Аян хур” ХХК-д 15 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Мөнх-Эрдэнэ), Татварын хэлтэс (А.Гантөмөр), Цагдаагийн газар (Э.Жавхлантөгс), Батноров сумын Засаг дарга (Б.Жавхланбаяр)-д тус тус мэдэгдэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, үйлдвэрлэлийн болон уулын ажлын үндсэн үзүүлэлтийг хуульд заасан хугацаанд багтаан батлуулах, үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах, холбогдох тайлан мэдээг цаг тухайд ирүүлж ажиллахыг “Аян хур” ХХК-д зөвлөсүгэй.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж, үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар хурандаа (Э.Жавхлантөгс), Татварын хэлтэс (А.Гантөмөр), Байгаль, орчин аялал жуулчлалын газар (Г.Мөнх-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2024

231011105